

**АУДИТЫН КОД: САГ-2018/16/СТА-ТЕЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663          Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261885          Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)

Ахлах аудитор Ц.Хосжаргал

Утас: 261628          Цахим хаяг: [khosjargalts@audit.gov.mn](mailto:khosjargalts@audit.gov.mn)

Аудитор Б.Уянга

Утас: 261628          Цахим хаяг: [uyangab@audit.gov.mn](mailto:uyangab@audit.gov.mn)

Улаанбаатар хот

## Агуулга

1.	Аудитын хураангуй тайлан.....	2
2.	Аудитын гэрчилгээ.....	6
3.	Аудитын тайлан.....	8
3.1.	Оршил.....	8
3.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	8
3.3.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	9
3.4.	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	11
3.5.	Дотоод аудит.....	12
3.6.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	13
3.7.	Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8.	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	14
3.9.	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	14
3.9.1.	Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар.....	14
3.9.2.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар.....	16
3.10.	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	17
3.11.	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд.....	17
3.12.	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	17
3.13.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.14.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	17
3.15.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	18
3.16.	Үр өгөөжийн тооцоолол.....	18
4.	Менежментийн захидал.....	19
4.1.	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг.....	20
4.2.	Бараа материал.....	20
4.3.	Мөнгөн хөрөнгө.....	21
4.4.	Дотоод аудит.....	21
5.	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	22
5.1.	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	22
5.2.	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	23
5.3.	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	24
5.4.	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	25
5.5.	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	26
5.6.	Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	

01

ТӨСВИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ  
ГАЗРЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР  
ТАНАА

2018.04.25 № 1018  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_Kheregi\Yawsan\_Bichig\2018\0425\SAG7.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

070413

## Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дугаар зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР



### 3. Аудитын тайлан

#### 3.1. Оршил

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.


#### 3.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (цаашид УСНББОУС гэх), түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.



Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.


Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 05-наас 2018 оны 4 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал, аудитор Б.Уянга нар хариуцаж хэрэгжүүлэв.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн ХЭГ/670 дугаар албан бичгээр Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

### 3.3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нь Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын танхимыг өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэгээр шуурхай хангах, Засгийн газрын тасралтгүй, хэвийн, үр ашигтай ажиллагааны зохистой орчин бүрдүүлэх чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь дор дурдсан үйл ажиллагаа, тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

- Засгийн газрын дотоод, гадаад бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр Засгийн газрын танхимд зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх;
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэл, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, бодлого, шийдвэрийг боловсруулан гаргахад Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын танхимын үйл ажиллагаанд бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;
- Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний шинэчлэлийн бодлого, орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого, төрийн албаны хүний нөөцийг давтан сургах асуудал, Засгийн газрын шийдвэрийн биелэлт, Засгийн газрын дотоод мэдээлэл, Засгийн газраас Улсын Их Хуралтай харилцах асуудал, орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалт, удирдлага, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд үзүүлэх мэргэжил, арга зүйн туслалцаа, Засаг даргын үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах ажилд арга зүйн зөвлөгөө, бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг чиглүүлж, бодлогын удирдамжаар хангах, зохицуулах, бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт, шалгалт хийх, мэдээлэх, үр дүнгийн үнэлгээг зохион байгуулах;
- Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг Засгийн газрын бодлого, нийтлэг зорилтод чиглүүлэн зохицуулах, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд зохион байгуулалтын болон мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж, тэдгээрийн идэвх бодлого, зорилго, үйл ажиллагааг хангах арга хэмжээ авах, аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа байдалд хяналт, шалгалт хийж, тэдгээрийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;



- Засгийн газрын үйл ажиллагааг цахим хэлбэрээр хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх замаар төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, мэдээллийн урсгалыг түргэтгэх, Засгийн газар-хувийн хэвшил, Засгийн газар-иргэний нийгмийн түншлэлийг хөгжүүлэх зэрэг болно.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын зарим үйл ажиллагааг төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан болно.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 311 арга хэмжээ төлөвлөснөөс 97.1 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2017 онд хэрэгжүүлсэн зарим хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2017 оны зорилтот түвшин	Биелэлт
<b>Гүйцэтгэх засаглалын удирдлага, түүний ажлын алба</b>		
17.1.1	Засгийн газрын бодлого, шийдвэрийг боловсруулах, хуралдаанд бэлтгэх болон яам, агентлагийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, энэ чиглэлээр цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх	хууль тогтоомжид нийцсэн байх
17.1.2	Ерөнхий сайд, Засгийн газрын танхим, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргыг нутгийн удирдлагын чиглэлээр мэргэжлийн өндөр, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэгээр шуурхай хангах, тэдгээрийн үйл ажиллагааны үр нөлөөтэй, хэвийн жигд ажиллагааны эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх	мэдээллээр хангасан байх
17.1.3	Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн мэдээллийг 2, 8 дугаар сард, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 3, 8 дугаар сард, хөтөлбөр, төслийн мэдээллийг 4 дүгээр сард, үйл ажиллагааны үр	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх
<p>Яамд, Засгийн газрын агентлагийн чиглэлээр Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр ирүүлсэн асуудлыг хүлээн авч, эрх зүйн үндэслэл, найруулга, ач холбогдлыг нь үнэлж, шалган ажилласан ба Засгийн газрын хуралдаанд 615 асуудал боловсруулж хэлэлцүүлэх, 200 асуудал танилцуулахад бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн ажилласан байна.</p> <p>Хөтөлбөрийн хүрээнд хуулиар хүлээсэн үүрэг зорилтыг хэрэгжүүлэх, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, үндсэн чиглэлд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх болон Ерөнхий сайд, Засгийн газрын танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх талаар бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн ажиллажээ. Засгийн газрын 57 удаагийн хуралдааныг зохион байгуулж, Засгийн газрын тогтоол 359, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 823, бодлогын баримт бичиг, хөтөлбөр 21, журам 30, дүрэм 16, төлөвлөгөө 8 гаргасан байна.</p> <p>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2017 оны эхний хагас жилийн дүнг Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанд, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 оны эхний хагас жилийн биелэлтийн хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанд тус тус танилцуулсан. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн 2017 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүн, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн</p>		



**Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын  
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит**

	дүнгийн мэдээллийг улирал тутам хийсэн байх		биелэлт, "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг Засгийн газрын 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанд тус тус танилцуулжээ. Үндэсний хөтөлбөр, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн мэдээлэл 2018 оны 5 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулагдахаар хүлээгдэж байна.
<b>Төр, засгийн үйлчилгээ</b>			
17.2.1	Төр, засгийн авто баазын үйлчилгээний стандартыг хангах	CS11-0120:2010 стандартыг ханган биелүүлсэн байх	Төр, засгийн авто тээврийн үйлчилгээнд CS11-0120:2010 стандартыг ханган ажилласан.
17.2.2	Төр, засгийн төв байгууллага болон хэрэглэгчийн хэвийн үйл ажиллагааг хангуулах	MNS-ISO 9001:2010 стандартыг ханган биелүүлсэн байх	Төр, засгийн төв байгууллагуудын нийтлэг үйлчилгээнд MNS-ISO 9001:2010 стандартыг ханган ажилласан.

Эх сурвалж: "shilendans.gov.mn" сайт.

### **3.4. Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 - 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжуулав.


Дотоод аудитын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 11 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 26 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа.

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой танилцахад 2015 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дараах чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна гэж үзлээ. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оныг 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлалтай холбоотой асуудал;





- Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй холбоотой асуудал;
- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн ашиглалт, мэдээллийн аюулгүй ажиллагаатай холбоотой бодлого зэрэг болно.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.

### 3.5. Дотоод аудит

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтыг “үр нөлөөгүй” гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим, сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Тус газар байгууллагын стратеги зорилтыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгын дор тайлант онд 4 зорилт дэвшүүлэн 29 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллажээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газар нь 2017 онд Засгийн газрын автобааз төрийн өмчит үйлдвэрийн газар, Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар улсын төсөвт үйлдвэрийн газарт дотоод аудит хийж, байгууллагын удирдлага, ажилтнуудад ажил сайжруулах чиглэлээр зөвлөмж, дүгнэлт өгч ажилласан байна.

#### Хүснэгт №2. Дотоод аудитын ажлын зарим үзүүлэлт

№	Үзүүлэлт	Дүн	
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо	4	
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо	3	
3	Шалгалтад хамрагдсан байгууллага, нэгжийн тоо	3	
4	Илрүүлсэн нийт зөрчлийн	Тоо	20
		Дүн (сая.төг)	542.2
5	Өгсөн зөвлөмжийн	Тоо	20
		Дүн (сая.төг)	542.2
6	Тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын	Тоо	01
		Дүн (сая.төг)	01

Эх сурвалж: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын 2017 оны тайлан.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

Дотоод аудитаар нийт 542.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, түрээсийн гэрээг холбогдох журмын дагуу шинэчлэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар баталгаажуулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөх, бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, авлага барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах зэрэг 20 зөвлөмж өгч ажиллажээ.

### 3.6. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцад 2017 онд хэрэгжүүлэх 2 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг 5 үзүүлэлтээр баталгаажуулжээ.

Дээрх хуулиар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг 895.5 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр гадаад тусламжийн орлого 556.9 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 271.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт зардалд 24,199.3 сая төгрөг, үүнээс урсгал зардалд 12,467.2 сая төгрөг, хөрөнгийн зардалд 5,763.3 сая төгрөг, гадаад зээл, тусламжаас санхүүжих зардалд 5,968.8 сая төгрөгийг баталжээ.

Төсөвт зардлын гүйцэтгэл нийт дүнгээрээ 20,994.7 сая төгрөг буюу 86.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Урсгал зардалд 16,486.7 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 1,949.3 сая төгрөгөөр, хөрөнгийн зардалд 4,508.0 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 1,255.3 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 55, 282 дугаар тушаалаар орон нутагт 2,054.6 сая төгрөгийн, харьяа байгууллагад 2,503.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний захиалагчийн эрхийг шилжүүлж, ажлын гүйцэтгэлээр орон нутагт 2,042.8 сая төгрөг, харьяа байгууллагад 1,259.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 1,205.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг бүрэн зарцуулсан байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсөвт зардлыг ерөнхий ангиллаар хэтрүүлэн зарцуулаагүй байна.

Нэмэлт санхүүжилтээр Засгийн газрын нөөц сангаас 259.0 сая төгрөг, төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 775.3 сая төгрөг нийт 1,034.3 сая төгрөг төвлөрснөөс 875.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Зарцуулагдаагүй 159.1 сая төгрөгийн үлдэгдлийн 68.0 хувийг Төв төрийн санд төвлөрүүлж, 32.0 хувийг холбогдох байгууллагад буцаан шилжүүлсэн байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим



хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна. Үүнд:

- Дараа жилийн төсвийн төсөл (бүтэн жилээр)
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (бүтэн жилээр, хагас жилээр, улирал бүр, сар бүр)
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (тухай бүр)
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил, үйлчилгээний гүйлгээ (тухай бүр)
- Байгууллагын батлагдсан төсөв (бүтэн жилээр)

### 3.8. Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 17 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 26 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.9-д хураангуйлан тэмдэглэв.

### 3.9. Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

3.9.1. Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар


Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа 9 байгууллагын санхүүгийн тайланд 7 хараат бус аудитын компани аудит хийж, “Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр”-ийн санхүүгийн тайланд аудит хийгдэж байна.

Дээрх аудитаар нийт 819.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 623.3 сая төгрөгийн алдааг залруулж, 1.4 сая төгрөгийн зөрчилд акт, 194.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмжийг өгсөн байна.

Энэ нь Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газар Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д "... төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт шалгалт өгөх, үнэлэлт зөвлөмж гаргах..." гэж заасан чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

**Шийдвэрлэсэн нь:** Тус газар нь харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах, төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулж, түүнд тавих хяналтыг дээшлүүлэх талаар үр дүнтэй ажил зохион байгуулах.

Аудитын түүвэрт хамрагдсан 4 байгууллагын санхүүгийн тайланд нийт 1,018.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 883.6 сая төгрөгийн алдааг залруулж, 94.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 40.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмжийг хүртүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:



#### а. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын санхүүгийн тайланд:

- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар, 2015 оны 7 дугаар, 2014 оны 55 дугаар тушаалуудыг тус тус зөрчиж санхүүгийн үр дүнгийн тайланд орлого, зардлыг 108.1 сая төгрөгөөр илүү тусгасан, үнэ төлбөргүй шилжүүлсэн 176.0 сая төгрөгийн хөрөнгийн зардлыг мэдээлэл, технологийн үйлчилгээний зардалд, 23.0 сая төгрөгийн тээвэр шатахууны зардлыг цалингийн зардал, ашиглалтад байгаа 5.4 сая төгрөгийн хангамжийн материалыг зардлын дансанд тус тус бүртгэж эдийн засгийн ангиллыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Аудитын явцад дээрх алдааг санхүүгийн тайланд залруулав.

- Хэрэгцээ шаардлага хангахгүй, эвдэрсэн 4.4 сая төгрөгийн бараа материалыг акталж, данс бүртгэлээс хасаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т "... засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайланд хэрэгцээ шаардлага хангахгүй, эвдэрсэн бараа материалыг тусгасан асуудлыг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлэх зөвлөмж өгөв.

- Бүрдэл дутуу анхан шатны баримтаар нийт 30.3 сая төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгасан нь тайлант үед хамаарах ажил гүйлгээний талаар иж бүрэн, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлүүд болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.


**Шийдвэрлэсэн нь:** Цаашид анхан шатны баримтын бүрдлийг хангаж байх, тайлант оны ажил гүйлгээг үнэн зөв бүртгэж байх зөвлөмж хүргүүлэхээр тогтов.

- Харилцах данснаас Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 6.3-т "Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянган) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ - 500,000 (таван зуун мянган) төгрөгөөс хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчиж жижиг мөнгөн санд их хэмжээний бэлэн мөнгө төвлөрүүлж, бараа, ажил үйлчилгээний төлбөрт тогтоосон хязгаараас хэтрүүлэн зарцуулсан байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг дагаж мөрдөх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

- Засгийн газрын харьяа байгууллагуудаас 26.0 сая төгрөг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвөөс 11.8 сая төгрөг нийт 37.8 сая төгрөгийг уралдаан тэмцээн, урлагийн тоглолт, хүлээн авалтын зардалд үр ашиггүй зарцуулжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэсэн заалттай зөрчилдсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Дээрх зөрчлийг холбогдох албан тушаалтанд давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.



- Суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтад заагдаагүй албан тушаалтнууд /тухайлбал: Ерөнхий сайдын туслах, хэлтсийн дарга, ерөнхий сайдын хэвлэлийн төлөөлөгч, шинжээч, шадар туслах/ автомашин хэрэглэж 47.5 сая төгрөгийн, мөн суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтнууд хот дотор явах лимитээ 1.3 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Засгийн газрын 2015 оны "Суудлын автомашин ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 184 дүгээр тогтоолын 2 дахь заалт болон уг тогтоолын хавсралтад заасан эрхийг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### **б. Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны санхүүгийн тайланд:**

- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар, 2015 оны 7 дугаар, 2014 оны 55 дугаар тушаалуудыг тус тус зөрчиж санхүүгийн үр дүнгийн тайланд орлого, зардлыг 25.0 сая төгрөгөөр илүү, 5.5 сая төгрөгийн томилолтын зардлыг тээвэр шатахууны зардалд бүртгэж эдийн засгийн ангиллыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Аудитын явцад дээрх алдааг санхүүгийн тайланд залруулав.

- Суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтад заагдаагүй албан тушаалтнууд /Шадар сайдын ахлах зөвлөх/ автомашин хэрэглэж 8.0 сая төгрөгийн шатахуун зарцуулсан нь Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын хавсралтад заасан эрхийг зөрчсөн байна.


**Шийдвэрлэсэн нь:** Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.9.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт шинээр гарсан стандарт, журамтай нийцүүлэн өөрчлөлт оруулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "... байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай зөрчилдөж байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан стандарт, журамтай нийцүүлэн өөрчлөлт оруулж, санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллага хоорондын орлого, зардлын гүйлгээг үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд 546.1 сая төгрөгөөр устгах бичилтийг дутуу хийсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн ерөнхийлөн захирагч болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын 4.2.2-т "Давхардсан ажил гүйлгээг устгах бичилтийг бүрэлдэхийнхэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.





**Шийдвэрлэсэн нь:** Дээрх журмын дагуу санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдэв.

### 3.10. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал хандуулах бусад асуудал түүвэрлэн үзсэн горимын хувьд байхгүй байна.

### 3.11. Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд 2018 оны завсрын аудитаар цалин тогтоолт, бүтэц орон тоонд нарийвчилсан горим, сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

### 3.12. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,837.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн.

Үүнээс, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон энэ хүрээнд түүвэрт хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 1,018.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитаар нягтлан бодох бүртгэлийн 883.6 сая төгрөгийн алдааг залруулж, 94.6 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгч, 40.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 4 зөвлөмж хүргүүлжээ.

Нэгтгэлд хамрагдсан харьяа 9 байгууллагын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 819.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитаар 623.3 сая төгрөгийн алдааг залруулж, 1.4 сая төгрөгийн зөрчлийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр 1 төлбөрийн акт тогтоож, 194.9 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 13 зөвлөмж хүргүүлсэн байна.

### 3.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Үндэсний аудитын газраас Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 20 зөвлөмжийн биелэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар 81.2 хувьтай байна.


Энэ зөвлөмжийн хэрэгжилтэд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт - шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавьж ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Х/711 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

### 3.14. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурийг тооцохдоо 2017 оны батлагдсан зардлын төсвийг суурь үзүүлэлт болгон сонгов.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэл 34,375.1 сая



төгрөг бөгөөд түүний 2 хувиар буюу 687.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурийг санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгох болсон шалтгаан нь тайлант онд нэмэлт санхүүжилтээр нийт 1,034.3 сая төгрөг орлого төвлөрч 875.2 сая төгрөгийг зарцуулсан, мөн 335.1 сая төгрөгийн үйл ажиллагааны бус зардал гарсантай холбоотой юм. Материаллаг байдлын түвшинг Санхүүгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын зөвшөөрлөөр өөрчилсөн болно.

### **3.15. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж **“Зөрчилгүй”** санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 3.14-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3.16. Үр өгөөжийн тооцоолол**

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 56.8 сая төгрөгийн үр өгөөжийн тооцооллыг хийж, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн удирдлагаар баталгаажуулсан болно.



#### 4. Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.


Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.




<b>4.1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг</b>	Тэргүүлэх ач холбогдол №1
<p><b>ҮАГ-ын ажиглалт:</b> Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт шинээр гарсан стандарт, журамтай нийцүүлэн өөрчлөлт оруулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "... байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай зөрчилдөж байна.</p> <p><b>Эрсдэлүүд:</b> Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх</p>	<p><b>ҮАГ-ын зөвлөмж:</b> Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан стандарт, журамтай нийцүүлэн өөрчлөлт оруулж, санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах</p> <p>Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.</p> <p><b>Төсвийн захирагчийн хариу:</b> Асуудлын бүртгэлээр удирдлагад танилцуулж баталгаажуулав.</p>

<b>4.2. Бараа материал</b>	Тэргүүлэх ач холбогдол №2
<p><b>ҮАГ-ын ажиглалт:</b> Ашиглалтад байгаа 5.4 сая төгрөгийн хангамжийн материалыг зардалд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалтыг зөрчсөн байна.</p> <p>Хэрэгцээ шаардлага хангахгүй, эвдэрсэн 4.4 сая төгрөгийн бараа материалыг акталж, данс бүртгэлээс хасаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т "... засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.</p> <p><b>Эрсдэлүүд:</b> Хөрөнгө алга болох, шамшигдах</p>	<p><b>ҮАГ-ын зөвлөмж:</b> 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулга хийх.</p> <p>Санхүүгийн тайланд хэрэгцээ шаардлага хангахгүй, эвдэрсэн бараа материалыг тусгасан асуудлыг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлэх. Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.</p> <p><b>Төсвийн захирагчийн хариу:</b> Асуудлын бүртгэлээр удирдлагад танилцуулж баталгаажуулав.</p>



<p><b>4.3. Мөнгөн хөрөнгө</b></p>	<p>Тэргүүлэх ач холбогдол №3</p>
<p><b>ҮАГ-ын ажиглалт:</b> Бүрдэл дутуу анхан шатны баримтаар нийт 30.3 сая төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгасан нь тайлант үед хамаарах ажил гүйлгээний талаарх иж бүрэн, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлүүд болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна. Харилцах данснаас Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 6.3-т "Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянган) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ - 500,000 (таван зуун мянган) төгрөгөөс хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчиж жижиг мөнгөн санд их хэмжээний бэлэн мөнгө төвлөрүүлж, бараа, ажил үйлчилгээний төлбөрт тогтоосон хязгаараас хэтрүүлэн зарцуулсан байна. <b>Эрсдэлүүд:</b> Бэлэн мөнгө шамшигдах, хяналт сулрах.</p>	<p><b>ҮАГ-ын зөвлөмж:</b> Цаашид анхан шатны баримтын бүрдлийг хангах.  Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайдын ажлын алба төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг дагаж мөрдөх  Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.  <b>Төсвийн захирагчийн хариу:</b> Асуудлын бүртгэлээр удирдлагад танилцуулж баталгаажуулав.</p>
<p><b>4.4. Дотоод аудит</b></p> <p><b>ҮАГ-ын ажиглалт:</b> Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 819.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 623.3 сая төгрөгийн алдааг залруулж, 1.4 сая төгрөгийн зөрчилд акт, 194.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна. Энэ нь Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газар Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д "... төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ хөрөнгө оруулалтад хяналт шалгалт өгөх, үнэлэлт зөвлөмж гаргах..." гэж заасан чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.  <b>Эрсдэлүүд:</b> Төсвийг зориулалт бус, үрэлгэн зарцуулах</p>	<p>Тэргүүлэх ач холбогдол №4</p> <p><b>ҮАГ-ын зөвлөмж:</b> Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах, төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулж, түүнд тавих хяналтыг дээшлүүлэх талаар үр дүнтэй ажил зохион байгуулах.  Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.  <b>Төсвийн захирагчийн хариу:</b> Асуудлын бүртгэлээр удирдлагад танилцуулж баталгаажуулав.</p>





## 5. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 5.1. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,932,530.1	14,096,511.9
МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,744,730.4	7,995,649.9
АВЛАГА	1,566,447.1	1,621,434.8
УРЬДЧИЛГАА	256,435.3	651,727.8
БАРАА МАТЕРИАЛ	2,364,917.2	3,827,699.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	50,972,864.0	39,560,307.3
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	50,972,864.0	39,560,307.3
Биет хөрөнгө	50,923,193.5	39,388,088.6
Биет бус хөрөнгө	49,670.6	61,419.0
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	110,799.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	61,905,394.1	53,656,819.3
НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,026,356.4	2,362,465.9
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,026,356.4	2,362,465.9
Өглөг	262,051.2	356,738.1
Урьдчилж орсон орлого	1,764,305.2	2,005,727.8
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	59,879,037.7	51,294,353.3
Засгийн газрын хувь оролцоо	59,879,037.7	51,294,353.3
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	34,952,824.8	36,766,737.1
Хуримтлагдсан үр дүн	5,973,248.5	6,015,966.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	18,952,964.4	8,511,650.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	61,905,394.1	53,656,819.3



## 5.2. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	30,579,902.5	36,151,886.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,513,441.7	18,610,810.3
Нийтлэг татварын бус орлого	13,707,885.3	17,368,304.0
Хөрөнгийн орлого	248,275.0	682,170.3
Тусламжийн орлого	557,281.3	560,336.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,066,460.8	17,541,075.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	31,566,301.4	34,039,985.0
УРСГАЛ ЗАРДАЛ	28,646,604.6	31,252,937.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,752,850.0	29,501,838.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,728,218.7	11,407,725.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,063,580.9	1,256,385.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,007,177.0	2,201,779.0
Хангамж, бараа материалын зардал	2,745,435.7	2,971,729.0
Нормативт зардал	27,124.8	23,575.8
Эд хогшил, урсгал засварын зардал	1,425,103.2	1,059,468.6
Томилолт, зочны зардал	912,543.3	856,157.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,371,078.8	5,466,296.1
Бараа үйлчилгээний бусад зардал	5,472,587.6	4,258,721.8
ТАТААС	-	85,548.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,893,754.6	1,665,551.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,919,696.8	2,787,047.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(986,399.0)	2,111,901.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	405,027.4	1,175.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	294,985.2	335,079.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(876,356.8)	1,777,996.4

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

### 5.3. Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/ өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,585,775.2		60,585,775.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60,585,775.2		60,585,775.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	83,101.1		83,101.1
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	86,518.3		86,518.3
Тайлант үеийн үр дүн	(876,356.8)		(876,356.8)
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,879,037.7		59,879,037.7
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	59,879,037.7		59,879,037.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(114.6)		(114.6)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	59,878,923.1		59,878,923.1
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(12,222,414.8)		(12,222,414.8)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	1,859,848.7		1,859,848.7
Тайлант үеийн үр дүн	1,777,996.4		1,777,996.4
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	51,294,353.3		51,294,353.3




#### 5.4. Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	29,503,055.0	35,510,620.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,182,618.5	17,797,126.0
Нийтлэг татварын бус орлого	12,375,312.2	17,240,179.9
Хөрөнгийн орлого	250,025.0	
Тусламжийн орлого	557,281.3	556,946.1
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,320,436.6	17,713,494.0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,833,595.1	28,742,727.7
УРСГАЛ ЗАРДАЛ	24,833,595.1	28,742,727.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,966,935.5	27,008,659.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,713,352.6	11,338,323.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,139,785.7	1,308,862.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,011,585.6	2,273,193.5
Хангамж, бараа материалын зардал	2,581,074.1	2,735,166.3
Нормативт зардал	91,209.2	58,183.8
Эд хогшил, урсгал засварын зардал	1,347,092.4	1,298,287.1
Томилолт, зочны зардал	892,609.2	892,215.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,472,129.0	6,005,705.0
Бараа үйлчилгээний бусад зардал	2,718,097.9	1,098,721.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,866,659.6	1,734,068.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,669,460.0	6,767,892.2
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,081,914.3	5,391,783.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,081,914.3	5,391,783.3
Дотоод эх үүсвэрээр	4,081,914.3	5,391,783.3
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(4,081,914.3)	(5,391,783.3)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	404,755.3	(125,189.4)
Бусад эх үүсвэр	404,755.3	941.6
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		126,131.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	992,301.0	1,250,919.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,752,429.4	6,744,730.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,744,730.4	7,995,649.9




## 5.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,199,317.4	20,994,679.5	3,204,637.9	86.8
УРСГАЛ ЗАРДАЛ	18,436,017.4	16,486,691.3	1,949,326.1	89.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,942,072.9	16,080,890.8	1,861,182.1	89.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,489,943.1	6,378,041.6	111,901.5	98.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	727,810.2	700,014.8	27,795.4	96.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	916,468.3	890,056.9	26,411.4	97.1
Хангамж, бараа материалын зардал	536,263.2	499,111.0	37,152.2	93.1
Нормативт зардал	18,857.9	18,547.0	310.9	98.4
Эд хогшил, урсгал засварын зардал	111,545.6	104,524.1	7,021.5	93.7
Томилолт, зочны зардал	1,025,781.8	790,207.5	235,574.3	77.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,863,617.2	5,961,528.7	902,088.5	86.9
Бараа үйлчилгээний бусад зардал	1,251,785.6	738,859.2	512,926.4	59.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	493,944.5	405,800.6	88,143.9	82.2
Засгийн газрын урсгал шилжүүлэг	705.0	-		
Засгийн газрын гадаад шилжүүлэг	705.0	-		
Бусад урсгал шилжүүлэг	493,239.5	405,800.6	87,438.9	82.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,763,300.0	4,507,988.2	1,255,311.8	78.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24,199,317.4	20,983,620.6	3,215,696.8	86.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,088,008.0	15,733,444.8	2,354,563.2	87.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,358,300.7	4,693,229.6	665,071.1	87.6
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	142,500.0	271,701.8	(129,201.8)	190.7
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	5,215,800.7	4,421,527.8	794,272.9	84.8
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	753,008.7	556,946.1	196,062.6	74.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,039,927.5	(2,039,927.5)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,027,868.6	(2,027,868.6)	





## 5.6. Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,038,080.3
УРСГАЛ ЗАРДАЛ	1,038,080.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,011,951.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41,517.3
Үндсэн цалин	41,517.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,531.5
Эрүүл мэндийн даатгал	4,531.5
Хангамж, бараа материалын зардал	143,833.5
Тээвэр, шатахуун	8,181.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	135,652.3
Нормативт зардал	3,936.7
Эд хогшил, урсгал засварын зардал	116,269.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	438,859.1
Бараа үйлчилгээний бусад зардал	263,004.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,128.6
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,128.6
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	26,128.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,034,284.2
Нэмэлт санхүүжилтийн орлого	1,034,284.2
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	259,010.0
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	775,274.2
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(3,796.1)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,128.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	331.9

